

Шилжин суурьшигчдад зориулсан оюуны хөрөнгө оруулалт, түүний үр дүн

А Солонго, МУИС-ийн ЭЗС-ийн багш, докторант

НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллагаас Зориг сантай хамтран шилжин суурьшигч залуу эмэгтэйчүүдийг чадваржуулах замаар тэдний өрхийн амьжиргааг дээшлүүлэх болон хот, суурин газарт дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор шилжин суурьшигчдад зориулсан “Шилжин суурьшигч тантай хамт” туршилтын төслийг 2005 онд нэг жилийн хугацаатай хэрэгжүүлсэн юм. Уг төсөлд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 12-16-р гэр хорооны нийт 280 хүн хамрагдсны 92.9 хувь нь сургалтын өмнөх судалгаанд, 74.3 хувь нь сургалтын дараах судалгаанд тус тус хамрагдлаа.

Төсөлд хамрагдагсдын дийлэнх нь “Шилжин суурьшигч тантай хамт” төсөлд хамрагдснаар өөрийн хүсч байсан үр дүндээ хүсч чадсан бөгөөд сэтгэл хангалуун байна. Төсөлд олон ам бүлтэй, шилжин ирсэн, өрхийн гишүүдийн ажил эрхлэлт нь доогуур, ядуу өрхийн гишүүд сонгогдсон байна. Мөн төсөлд хамрагдагсад нь залуу насны, сүүлийн таван жилд хотод шилжин ирсэн бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой байв. Төсөлд хамрагсдын гуравны нэг нь шилжин ирэлтээ бүртгүүлээгүй байсан ба гол шалтгаан нь орон нутагтаа шилжүүлэг хийлгээгүй, бичиг баримтын зөрчилтэй, санхүүгийн боломж муу байгаагаас болжээ. Харин төсөлд хамрагдснаар тэдний гуравны нэг нь шилжин ирэлтээ бүртгүүлсэн байна. Бүртгэлд хамрагдаж чадснаар өөрийн хорооны харьяа өрхийн эмнэлгээр өрхийн гишүүд нь үйлчлүүлдэг болсон хүмүүсийн хувийн жин өсчээ. Мөн төсөлд хамрагсдын өрхийн орлогод өөрчлөлт гарчээ. Гэхдээ төсөлд хамрагдсны дараа хүмүүсийн ердөө тал хувь нь ажил идэвхтэй хайсан байна. Түүнчлэн, тэдний хууль эрх зүйн мэдлэг, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг эрс дээшилсэн байна. Төсөлд оролцсноор эрүүл мэндийн даатгалд хамрагдах, энэ чиглэлээр өөрийн ойр дотны хүмүүстээ зөвлөх, даатгалаа хөөцөлдөж хийлгэх мэдлэг нь ч дээшилжээ. Өрхийн сургууль завсардсан хүүхдүүдээ сургуульдаа эргэн сурахад нь нөлөөлөх, ажилгүй насанд хүрэгчдийг ажилтай болгоход нь ч төсөлд оролцогчид нөлөөлж чаджээ. Сургалтад хамрагдснаар шилжин иргэчид найз нөхөдтэй болж, бие биедээ туслах, ажил хөдөлмөр хийх боломж нь нэмэгдэн, өөртөө итгэх итгэлтэй болсон байна.

Олон нийтийн оролцоог идэвхжүүлсэн энэхүү төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжүүлэн, бусад дүүрэг хороодод зориулсан загвар төсөл болгон ашиглах; мэргэжлийн сургалтын чиглэлүүдийг өргөтгөж, ажлын байранд дадлага хийх боломжийг нь нэмэгдүүлэх; хууль эрх зүй, эрүүл мэндийн мэдлэг, өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга зүйн асуудлаар мэдээ, мэдээллийг хангалттай хэвлэн нийтлүүлж, олон нийтэд тараах, ухуулан сурталчлах ажилд хорооны түвшинд нэгэнт бий болсон иргэдийн сүлжээг ашиглах зэрэг үйл ажиллагааны зөвлөмжүүдийг судалгааны үр дүнд суурилан санал болгожээ.

1. Үндэслэл

НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллагаас Зориг сантай хамтран шилжин суурьшигч залуу эмэгтэйчүүдийг чадваржуулах замаар тэдний өрхийн амьжиргааг дээшлүүлэх болон хот, суурин газарт дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор шилжин суурьшигчдад зориулсан “Шилжин суурьшигч тантай хамт” туршилтын төслийг 2005 онд нэг жилийн хугацаатай хэрэгжүүлсэн юм. Уг төсөлд шилжих хөдөлгөөн болон ядуурлын түвшин хамгийн өндөр байгаа Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Өнөр хорооллын 12-16-р хороодын амьжиргааны түвшин доогуур, шилжин ирсэн, залуучууд хамрагдав. Төслийн үндсэн үйл ажиллагаа нь төсөлд хамрагдагсдын хууль эрх зүй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэгийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, төсөлд хамрагдагсдын хэрэгцээнд суурилсан богино хугацааны мэргэжлийн дамжаанд хамруулан мэргэжил эзэмшүүлэхэд чиглэгдэж байв.

Төслийн хугацаа дууссны дараа төслийн хэрэгжилт болон зорилтод бүлэгт үзүүлж буй үр нөлөөг үнэлэх, цаашид анхаарах гол үйл ажиллагааг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдсан юм.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь төслийн үйл ажиллагаа, зорилтод бүлэгт үзүүлж буй үр нөлөөг үнэлэх явдал байв. Уг зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Шилжин суурьшигчдын хууль эрх зүй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг сургалтын дараа хэрхэн дээшилснийг тодорхойлох;
- Төслийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, цаашдын үйл ажиллагааны зөвлөмж гаргах;

2. Арга зүй, аргачлал

Уг судалгаа нь тоон судалгаа бөгөөд төсөлд хамрагдагсдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн шинж байдал, сургалтаас өмнө болон сургалтын дараа тэдний хууль эрх зүй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг, өрхийн амьжиргаанд гарч буй өөрчлөлтийг харьцуулан дүгнэх зорилгоор асуулгын хуудас боловсруулан ашиглав. Хороон засаг дарга, Зориг сангийн төсөл дэмжигчид, хүн ам зүйч мэргэжлийн ангийн оюутнуудын оролцоотойгоор ядуу бөгөөд шилжигч өрхөөр явж, төсөлд хамрагдвал зохих иргэдийг зорилттойгоор сонгон авсан. Мэдээлэл цуглуулах ажлыг МУИС-ийн ЭЗС-ийн Хүн ам зүйн 4-р ангийн оюутнууд хийж гүйцэтгэсэн. Мэдээллийг тархалтын давтамж, хамаарлын хүснэгтийг ашиглан тайлбар статистикийн аргаар нэгтгэн дүгнэв. Мөн мэдээлэл цуглуулах явцад олж авсан зарим кейс жишээгээр тайланг тодотгож өглөө.

Судалгааны хамрагдалт

“Шилжин суурьшигч тантай хамт” төсөлд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 12-16-р гэр хорооны нийт 280 хүн хамрагдсны 92.9 хувь буюу 260 хүн сургалтын өмнөх судалгаанд, 74.3 хувь буюу 208 хүн сургалтын дараах судалгаанд тус тус хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан хүн ам нь төсөлд хамрагдсан хүн амыг (эх олонлогыг төлөөлөх чадвар $n > 90$) бүрэн төлөөлж чадах учраас судалгааны тайланд “**төсөлд хамрагдсан хүн ам**” гэж цаашид нэрлэх болно.

3. Төсөлд хамрагдсан хүн амын шинж байдал

Өрхийн шинж байдал

Төсөлд хамрагдсан хүн амын 43.5 хувь нь 3-4 гишүүнтэй, 36.9 хувь 5 ба түүнээс олон гишүүнтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд өрхийн дундаж хүн амын тоо 5 байв. Тэдгээрийн 30.4 хувь нь 16 хүртэлх насны 1-2 хүүхэдтэй, 31.9 хувь нь мөн насны 3-4 хүүхэдтэй, дөрөвний нэг орчим хувь нь 5 ба түүнээс олон хүүхэдтэй өрхөд амьдарч байлаа.

Өрхөд амьдарч буй хүн амын боловсролын түвшингийн хувьд, дээд эсвэл техник мэргэжлийн боловсролтой хүн амын эзлэх хувийн жин төсөлд хамрагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины өрхөд бага байлаа. Өрхийн 16 ба түүнээс дээш настай хүн амд эдийн засгийн идэвхгүй хүн амын эзлэх хувийн жин 47-оос

дээш байгаа нь өрхийн орлогод нөлөөлөх гол хүчин зүйл болж байна. Төсөлд хамрагдагсдын өрхийн орлогын гол эх үүсвэр нь цалин (63.8 хувь) байгаа бөгөөд өрхийн сарын дундаж мөнгөн орлого 65453 төгрөг байна.

Төсөлд хамрагдагсдын гуравны нэг нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдарч байгаа боловч дийлэнх нь гэр сууцанд аж төрж байна. Төсөлд хамрагдахын өмнө тэдний ердөө 20 хүрэхгүй хувь нь оршин суугаа газраа өмчилж авсан байв. Төсөлд хамрагдагсад хэдийгээр бараг хотын төвийн гэр хороолол гэж хэлж болохоор газар амьдарч байгаа ч 17.7 хувь нь цахилгаанд холбогдоогүйн зэрэгцээ тээврийн ус зөөж хэрэглээгээ хангасаар байна. Түүнчлэн 76.9 хувь нь бохирын зориулалтын цооноггүй орчинд аж төрж байгаа нь халдварт өвчин тархах өндөр эрсдэлтэйг харуулж байна.

Төсөлд хамрагдсан хүн амын шинэ байдал

Төсөлд хамрагдагсдын шинэ байдлын сонгосон үзүүлэлтийг Хүснэгт 3.1-д харуулав. Төсөлд хамрагдсан хүн амын насны дундаж 24.4 (эмэгтэйчүүдийнх 24.9 нас, эрэгтэйчүүдийнх 20.1 нас) байгаа нь төсөлд залуу насны хүмүүс хамрагдсан болохыг илтгэж байна. Насны бүтцийн тархалтыг харахад 25-29 насны эмэгтэйчүүд (30.3 хувь) болон 20 хүртэлх насны эрэгтэйчүүдийн (63.6 хувь) эзлэх хувийн жин бусад насны бүлгээс хамгийн өндөр байлаа.

Тэдгээрийн гэрлэлтийн байдлыг авч үзвэл, талаас илүү хувь нь огт гэрлээгүй, 43.9 хувь нь гэрлэсэн, үлдсэн 6 орчим хувь нь салсан, бэлэвсэн хүмүүс байв. Хүйсээр авч үзэхэд эмэгтэйчүүдийн 45.8 хувь нь огт гэрлээгүй, 48 хувь гэр бүлтэй байхад эрэгтэйчүүдийн дийлэнх нь (82 хувь) гэрлээгүй залуучууд байлаа. Гэрлэлтийн энэхүү зөрүүтэй байдал нь төсөлд хамрагдагсдын насны бүтэцтэй холбоотой юм. Төсөлд хамрагдагсдын 50.8 хувь нь хүүхэдтэй хүмүүс байсан бөгөөд хүүхдийн дундаж тоо 1.8 байв. Төсөлд хамрагдсан хүн амын 60 орчим нь өөрийн гэртээ амьдарч байсан.

Төсөлд хамрагдагсдын дөнгөж 2.4 хувь нь тусгай мэргэжлийн, 1/2 орчим хувь нь бүрэн дунд, 1/3 нь бүрэн бус дунд, 11.9 хувь нь огт боловсролгүй эсвэл бага боловсролтой байв. Хүйсийн хувьд, эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдээс нилээд доогуур байна.

Төсөлд хамрагдсан хүн амын ердөө 18.5 хувь нь л ажил эрхэлж байгаагийн тал нь хувийн байгууллагад, 30 орчим хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байв. Харин үлдсэн 81.5 хувь нь огт ажилгүй хүмүүс байна. Мэргэжилгүй учраас ажил олдохгүй (59 хувь), хүүхэд өндөр настан асардаг (27.8 хувь), бүртгэл, бичиг баримтгүй (22.2 хувь) байгаа зэргийн улмаас тэд төсөлд хамрагдахын өмнө ажил эрхлээгүй байв.

Хүснэгт 3.1 Судалгаанд хамрагдагсдын хувийн жин, шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр

Шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
Нас			
20 хүртэл	63.6	24.7	29.5
20-24	18.2	21.6	21.2
25-29	12.2	30.3	28.1
30-34	3.0	18.1	16.2
35 ба дээш	3.0	5.3	5.0
Дундаж	<i>20.1</i>	<i>24.9</i>	24.4
Гэрлэлтийн байдал			
Огт гэрлээгүй	81.8	45.8	50.4
Гэрлэсэн	9.1	26.9	24.6
Хамт амьдардаг	6.1	21.1	19.3
Тусгаарласан/салсан	3.0	4.4	4.2
Бэлэвсэн	0.0	1.8	1.5
Төрүүлсэн хүүхдийн тоо			
Хүүхэд байхгүй	84.8	44.1	49.2
1	9.1	25.1	23.1
2	6.1	20.2	18.5
3+	0.0	10.6	9.2
Дундаж	<i>1.4</i>	<i>1.8</i>	1.8
Өөрийн өрхөд амьдарч байгаа эсэх			
Тийм	63.6	58.6	59.2
Үгүй	36.4	41.4	40.8
Боловсролын байдал			
Боловсролгүй/Бага	21.2	10.6	11.9
Бүрэн бус дунд	51.5	31.3	33.8
Бүрэн дунд	27.3	55.5	51.9
Тусгай мэргэжлийн	0.0	2.6	2.4
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	33	227	260

Шилжих хөдөлгөөний байдал

Төсөлд хамрагдагсдын 81.5 хувь нь Улаанбаатарт шилжин ирэгчид байв. Эдийн засгийн шалтгааны улмаас хотод шилжин ирэгчдийн эзлэх хувийн жин өндөр байна. Энэ нь орон нутагт ялангуяа сумын төвд ажлын байрны хомсдол их, ядуурал хамгийн өндөр¹ байгаатай шууд холбоотой юм. Харамсалтай нь шилжин ирэгчдийн 80 орчим хувь нь шилжин ирсэн зорилгоо биелүүлж чадаагүй ажээ. Шилжин ирсэн зорилгодоо хүрч чадаагүй эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс даруй 18 пунктээр илүү байв.

Шилжин ирэгчдийн бүртгэл

Шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүс бүгдээрээ шилжин ирсэн даруйдаа бүртгэл хийлгэдэггүй болох нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, хотод шилжин ирээд нэг жил болохдоо бүртгэл хийлгээгүй байгаа хүмүүсийн хувийн жин

¹ Дэлхийн банк, УСГ, 2003. Хүн амын өрхийн амьжиргааны түвшний судалгаа, Улаанбаатар

шилжин ирээд 1-2 жил болж байгаа хүмүүстэй харьцуулахад 1.6 дахин, 3-4 жил болсон хүмүүстэй харьцуулахад 2.4 дахин их байна.


Хүснэгт 3.2-д шилжин ирээд бүртгэл хийлгээгүй хүмүүсийн хувийн жинг бүртгүүлээгүй шалтгаан болон хотод амьдарч буй хугацаагаар харуулав.

<i>Хүснэгт 3.2 Төсөлд хамрагдсан бүртгэлгүй шилжин ирэгсдийн хувийн жин, бүртгүүлж чадахгүй байгаа шалтгаан, шилжин ирээд амьдарсан хугацаагаар</i>				
Бүртгүүлж чадахгүй байгаа шалтгаан	Хотод амьдарч буй хугацаа			Нийт
	1 хүртэл жил	1-2 жил	3-4 жил	
Баримт бичиг байхгүй	10.5	6.1	29.4	12.5
Орон нутгийн шилжүүлэггүй	47.4	57.6	41.2	50.0
Санхүүгийн боломжгүй	13.2	9.1	5.9	10.2
Бүртгүүлж амжаагүй	28.9	27.3	23.5	27.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Тоо	38	33	17	88

Шилжих хөдөлгөөнд оролцоод шилжилтээ бүртгүүлж амжаагүй байгаа хүмүүсийн тал хувь нь орон нутгийн шилжүүлгээ хийлгээгүйн улмаас бүртгүүлж чадахгүй байгаа ажээ. Харин шилжин ирэгсдийн 12.5 хувь нь бичиг баримтгүй, 10.2 хувь нь санхүүгийн боломжгүй гэсэн шалтгаануудаар бүртгүүлээгүй байхад нэлээд хувь (27 хувь) нь бүртгүүлэхэд ямар нэг саадгүй боловч бүртгүүлж амжихгүй яваа хүмүүс байлаа.

Иргэний оролцоо, эрх мэдэл

Хүний хөгжил гэдэг бол эрх мэдэлтэй байхыг хэлдэг. Иймд хөгжилд иргэд тэр дундаа ядуу иргэдийн өөрсдийн оролцоо нэн чухал юм. Төсөлд хамрагдсан шилжин суурьшигчдийн сонгуулийн оролцоо муу байна. Тухайлбал, 2004 оны УИХ-ын сонгуульд эмэгтэйчүүдийн 56.7 хувь, 2004 оны орон нутгийн сонгуульд 45.4 хувь, 2005 оны ерөнхийлөгчийн сонгуульд 60.4 хувь нь тус тус оролцжээ. Бүх шатны сонгуульд төсөлд хамрагдсан эрэгтэйчүүдийн гуравны нэгд ч хүрэхгүй хувь нь оролцсон байна (Зураг 3.1).



Төсөлд хамрагдсан хүн амтай оршин амьдарч буй дүүрэг эсвэл хороодын зүгээс төсөлд хамрагдахаас өмнө ахуй амьдралтай нь танилцаж байсан эсэхийг тодруулж сонирхоход 50.8 хувь нь “Тийм” гэж хариулсан байна.

Шилжин ирэгчдийн чадавхи

Төсөлд хамрагдагсдын 16.5 хувь нь “Шилжин суурьшигч таньтай хамт” төсөлд оролцохоосоо өмнө ажил, мэргэжлийн дадлага олгох, сургалт, дамжаанд хамрагдаж байжээ. Тэдгээрийн 37.2 хувь нь тогооч, нарийн боовчны, 16.3 хувь нь зөөгч/бармен, 13.8 хувь нь худалдагч, нярвын дамжаа гэх мэт голдуу үйлчилгээний чиглэлийн мэргэжлээр суралцсан байна. Үлдсэн 30 гаруй хувь нь барилгын засал чимэглэл, оёдол, компьютер, хэлний дамжааг дүүрэгжээ. Дээрх дамжаанууд нь ач холбогдолтой байсан гэж тэдний 62.8 хувь нь үнэлж байгаа боловч ердөө гуравны нэг нь амьжиргаагаа дээшлүүлж чадсан байна.

Төсөлд хамрагдахаас өмнө оролцогчид санхүү, мөнгөний боломжгүй (50 хувь), хангалттай мэдээлэл байхгүй (20 хувь) зэргээс шалтгаалаад мэргэжлийн болон ажлын ур чадвар олгох сургалт, дамжаанд хамрагдаж чадаагүй байна.

4. Төсөлд хамрагдагсдын Хууль эрхзүй, Эрүүл мэнд, Хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд

Сэтгэл зүйд гарсан өөрчлөлт

Төсөлд хамрагдагсдын 93.3 хувь нь сургалтад хамрагдснаар амьдралд нь өөрчлөлт гарсан гэж үзэж байв. Найз нөхөдтэй болсон, өөртөө итгэх итгэлтэй болсон, мэргэжилтэй болж ажил хөдөлмөр хийх боломж нэмэгдсэн, хүмүүс хүндэлдэг болсон зэрэг өөрчлөлтүүд гарсанд төсөлд хамрагдагсад илүү их ач холбогдол өгч байна.

Шилжин ирээд орж гарч байх хүн амьтан байхгүй, гэртээ л байдаг байсан. Хаашаанаас гардаггүй болохоор хүн ч таньдаггүй. Төсөлд хамрагдаад манай бүлгийнхэн манайхаар ирдэг болсон. Нөхөр ийшээ, тийшээ яваад ирье гэхэд хориод байдаггүй болсон.

(М. 29 настай, эмэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, баталгаагүй гэр бүлтэй)

Хоол унд муу бол нэгийнхээсээ зээл авах, бие биедээ туслах зэргээр орж гардаг болсон. Нэг удаа үсчний курсээ тараад нэлээд оройтсон. Манай бүлгийн Ц нөхрөөсөө айгаад бид хүргэж өгсөн. Зодохгүй биз дээ гээд хараад байсан тэр их сандраад байсан. Ер нь зоддог юм билээ. Нэг удаа цагдаа дуудсан таксийдаад хүрээд ир гээд тоохгүй байсан. Бид очиж нөхөртэй нь уулзсан. Ц-д аль болох чадах ядахаараа туслахыг хичээдэг. Энэ төсөлд хамрагдснаар сэтгэл их өндөр байгаа. Энд хамрагдснаар нөхөр нь зодох нь багассан гэсэн.

(С. 31 настай, эмэгтэй, бүрэн дунд боловсролтой, гэр бүлтэй)

Хууль эрх зүй, Эрүүл мэнд, Хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэгт гарсан өөрчлөлт

Төсөлд хамрагдсан хүн амын хууль эрх зүйн мэдлэгийг хэд хэдэн багц асуултуудаар тестийн аргаар тодорхойлсон болно. Үр дүнг Хүснэгт 4.1-д харууллаа. Төсөлд хамрагдсны дараа хүн амын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.

Хүснэгт 4.1 Төсөлд хамрагдагсдын хувийн жин, хууль, эрх зүйн мэдлэгийн сонгосон үзүүлэлт, сургалтын өмнө болон дараа

Сонгосон үзүүлэлтүүд	Сургалтын өмнө			Сургалтын дараа		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
<i>Газрын тухай эрх зүйн мэдлэг</i>						
Мэдлэгтэй	36.3	40.5	40.0	92.9	93.3	93.3
Мэдлэггүй	63.7	59.5	60.0	7.1	6.7	6.7
<i>Хөдөлмөрийн хуулийн талаарх мэдлэг</i>						
Зөв мэдлэгтэй	12.1	15.0	14.6	28.6	30.4	30.3
Буруу мэдлэгтэй	85.0	87.9	85.4	71.4	69.6	69.7
<i>Ядуу амьдралтай өрхийг тодорхойлж буй байдал</i>						
Зөв мэдлэгтэй	3.0	2.6	2.7	7.1	33.0	31.3
Буруу мэдлэгтэй	97.0	97.4	97.3	92.8	67.0	68.7
<i>Хүчирхийллийн талаарх хууль эрх зүйн мэдлэг</i>						
Мэдлэгтэй	36.4	49.3	47.7	71.4	85.6	84.6
Мэдлэггүй	63.6	50.7	52.3	28.6	14.4	15.4
<i>Эрх ашгаа хамгаалах хууль эрх зүйн мэдлэг эзэмшиж чадсан эсэх</i>						
Чадсан	30.3	19.4	20.8	79.9	71.4	79.3
Чадаагүй	69.7	80.6	79.2	20.1	28.6	20.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	33	227	260	14	194	208

Газрын тухай эрх зүйн мэдлэг: Төсөлд хамрагдахаас өмнө хүн амын ердөө 40 хувь нь л газрын тухай хуулийн талаар мэдлэгтэй байсан бол сургалтын дараа 93.3 хувь нь энэ талын мэдлэгтэй болжээ.

Хөдөлмөрийн хуулийн талаарх мэдлэг: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасан ажлын өдөр, цагийн үргэлжлэх хугацаа, амралт, баяр ёслолын өдрөөр амрах эрх, илүү цагаар ажилласны хөлс төлөгдөх журам зэргийг багцлан уг үнэлгээг хийсэн. Төсөлд хамрагдахаас өмнө хүн амын дөнгөж 14.6 хувь л хөдөлмөрийн хуулийн талаар бүрэн зөв мэдлэгтэй байсан бол сургалтын дараа зөв мэдлэгтэй хүн амын хувийн жин 2 дахин нэмэгдэж 30.3 хувь болсон байна.

Өрхийн амьжиргааны түвшинг тогтоож буй аргын талаар: Өөрийн өрхийг ядуу, эмзэг гэж тодорхойлох хандлага хороодын түвшинд өндөр байдаг тул энэ талын мэдлэг хүн амын дунд ямар байгааг тодорхойлохыг зорьсон юм. Нэн ядуу өрхийг амьжиргааны баталгаажих доод түвшингийн 40 хувиар тогтоодог гэдгийг төсөлд хамрагдахаас өмнө хүн амын ердөө гуравхан хувь мэдэж байсан бол сургалтын дараа 31.3 хувь нь мэддэг болж даруй 10 дахин нэмэгджээ.

Хүчирхийллийн талаарх хууль эрх зүйн мэдлэг: Төсөлд хамрагдахаас өмнө хүн амын тал хүрэхгүй хувь нь хүчирхийллийн талаар хууль, эрх зүйн мэдлэгтэй байсан бол сургалтын дараа 84.6 хувь нь энэ талын мэдлэгтэй болсон байна.

Эрх ашгаа хамгаалах хууль эрх зүйн мэдлэг: Өөртөө итгэх итгэл, өөрийхөө эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн мэдлэг эзэмшсэн хүн амын хувийн жин 20.8-аас 79.3 болж төсөлд хамрагдахаас өмнөх түвшинтэй харьцуулахад 4 дахин нэмэгдсэн байна. Эмэгтэйчүүдийн хувьд төсөлд хамрагдахаас өмнө 20 хүрэхгүй хувь нь эрх ашгаа хамгаалах хууль эрх зүйн мэдлэгтэй байсан бол сургалтын дараа 71.4 хувь болж эрс дээшилжээ.

Бүртгэлд хамрагдалтын байдалд гарсан өөрчлөлт

Төсөлд хамрагдсан хүн амын 64.9 хувь нь төсөлд оролцохоос өмнө шилжин ирэлтээ бүртгүүлчихсэн байсан бол сургалтын дараа 76.9 болж даруй 12 пунктээр нь нэмэгджээ.

Төсөлд хамрагдсны дараа бүртгэлгүй байсан нийт хүн амын 34.2 хувь, (эмэгтэйчүүдийн 31.8 хувь, эрэгтэйчүүдийн 57.2 хувь) нь шилжин ирэлтээ бүртгүүлж, бичиг баримтын зөрчилгүй болжээ.

Төсөлд хамрагдсан хүн ам зөвхөн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ засаг захиргааны нэгжид заавал бүртгүүлэх ёстой гэсэн иргэний үүргээ сайн мэддэг, хаана очиж бүртгүүлэх ёстойгоо ч сайн мэддэг болжээ. Хаана бүртгүүлэхээ мэддэг хүн амын хувийн жин бараг 2 дахин өссөн нь төслийн томоохон амжилт гэж хэлж болохоор байна. Мөн тэдний 94.7 хувь нь шилжих хөдөлгөөний талаар тодорхой ойлголттой болж, шилжин ирэгчийн бүртгэлийг заавал хийлгэх ёстой гэж 70.7 хувь нь өөрийн ойр дотны болон бусад хүмүүст зөвлөгөө өгсөн байна.

Эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд гарсан өөрчлөлт

Шилжин суурьшигчдийн дунд тулгамдаж буй нийгмийн асуудлуудын нэг нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж² юм. Төсөлд хамрагдагсдын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжид нь өөрчлөлт гарсан эсэхийг тодруулж үр дүнг Хүснэгт 4.2-д дэлгэрэнгүй харуулав.

Сонгосон үзүүлэлтүүд	Сургалтын өмнө			Сургалтын дараа		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<i>Эрүүл мэндийн даатгалтай эсэх</i>						
Даатгалтай	60.6	62.1	61.9	64.3	67.5	67.3
Даатгалгүй	39.4	37.9	38.1	35.7	32.5	32.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	33	227	260	14	194	208

Төсөлд хамрагдахаас өмнө хүн амын 61.9 хувь нь эрүүл мэндийн даатгалтай байсан бол сургалтын дараа даатгалтай хүн амын хувийн жин 67.3 болж 5.6 пунктээр нэмэгджээ. Төсөлд хамрагдсан 10 эмэгтэй тутмын нэг нь сургалтын дараа эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Харин даатгалтай гэж хариулсан эрэгтэйчүүд бүгд төсөлд хамрагдахаасаа өмнө даатгуулчихсан байжээ.

Сургалтын өмнө даатгалгүй хүн амын 37.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд хаана хандахаа мэднэ гэж байсан бол сургалтын дараа энэ үзүүлэлт 72.1 хувь болж эрүүл мэндийн даатгал хийлгэх мэдлэгтэй хүн амын хувийн жин бараг 2 дахин нэмэгдсэн байна. Эндээс, эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд хаана, хэрхэн хандах талаар төсөлд хамрагдагсдын гуравны нэг нь мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.

² НХХЯ, ХАССТ, НҮБХХ, 2004. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, судалгааны тайлан, Улаанбаатар

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэгт гарсан өөрчлөлт

Сургалтын дараа төсөлд хамрагдсан хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийн түвшин дээшилсэн байна (Хүснэгт 4.3). Тухайлбал, жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын мэдлэгийн түвшин сургалтаас өмнө 88.5 хувьтай байсан бол сургалтын дараа 99.0 хувь болж 10 гаруй пунктээр, уламжлалт аргын мэдлэгийн түвшин 56.9 хувиас 74.5 хувь болж 17.6 пунктээр тус тус нэмэгджээ. Цаашилбал, үр хөндөлтийн талаар зөв мэдлэгтэй хүн амын хувийн жин 6.7 пунктээр, бэлгийн замын халдварт өвчний тархалтын талаар зөв ойлголттой байгаа хүн амын хувийн жин 3 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4.3 Төсөлд хамрагдагсдын хувийн жин, гэр бүл төлөвлөлтийн аргын талаарх мэдлэг, сургалтын өмнө болон дараа

Сонгосон үзүүлэлтүүд	Сургалтын өмнө			Сургалтын дараа		
	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
ЖСАХ-ийн талаарх мэдлэг						
Орчин үеийн арга	84.8	89.0	88.5	100.0	99.0	99.0
Уламжлалт арга	45.5	58.6	56.9	71.4	74.7	74.5
Үр хөндөлт ГБТ-ийн арга мөн эсэх						
Зөв мэдлэгтэй	70.8	70.0	70.2	71.4	78.4	77.9
Буруу мэдлэгтэй	29.2	30.0	29.2	28.6	21.6	22.1
Бэлгийн замын халдварт өвчний талаарх мэдлэг						
Зөв мэдлэгтэй	97.0	95.9	96.0	100.0	99.0	99.0
Буруу мэдлэгтэй	0.0	0.9	0.8	0.0	0.5	0.5
Огт мэдлэггүй	3.0	3.2	3.2	0.0	0.5	0.5
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	33	270	260	14	194	208

Ажил эрхлэлт, өрхийн амьжиргаанд гарч буй өөрчлөлтүүд

Төсөлд хамрагдахаас өмнө судалгаанд хамрагдсан нийт хүн амын ердөө 14.9 хувь нь л ажил эрхэлдэг байсан бол төсөлд хамрагдсны дараа 43.7 хувь нь ажил эрхэлдэг болж энэ үзүүлэлт 28.8 пунктээр нэмэгдсэн байна. Төсөлд хамрагдсны үр дүнд ажилтай болсон эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс 7.3 пунктээр илүү байна. Төсөлд хамрагдаж мэргэжилтэй болсон хүмүүс ур чадварын хувьд гологдохгүй байна.

Төслийн сургалтаа төгсөөд хувийн үсчинд ажил орохоор шалгалт өгсөн. Анх очиход төслөөс сургалтад хамрагдсан гэхэд тааруухан хүлээж авч байсан. Бусад хүмүүстэй адилхан шалгалт өгөөд тэнцсэн. Багаж хэрэгслийг маань муу байсан болохоос ур чадварын хувьд сайн байсан гэсэн. Манай нөгөө бүлгийн тогоочоор төгссөн нэг хүүхнийг бас сайн байна гэсэн. Тэр одоо ажил хийж байна.

(Д. 22 настай, бүрэн бус дунд боловсролтой, гэрлээгүй.)

Уг нь мэргэжилдээ сайн гэж үнэлэгдсэн. Гэтэл хөрслөг бор царайтай учраас гоо сайханд таарахгүй, тэнцэхгүй гэдэг. Байранд байдаггүй болохоор манай дэнжийнхэн усанд тэр бүр ороод байх биш дээ. Гар хүртэл ширүүн байдаг юм. Ажил хайж олон газраар явсан. Нэг хоёр хоног хүлээж бай гээд дорвитой хариу өгөхгүй юм. Нөхөртэйгөө хашаандаа 2 ортой гоо сайхны газар байгуулдаг юм уу гэж ярьсан. Хүмүүстэй нийлж байгаад хотын төвтэй адил өндөр үнээр биш энэ хавийнхандаа тохирох үнээр хямд үйлчилгээ үзүүлье гэж бодож байгаа.

(Д. 25 наатай, эмэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, гэр бүлтэй)

Өрхийн эдийн засаг, нийгмийн асуудлуудад оруулж буй хувь нэмэр

Хүснэгт 4.1-д төсөлд хамрагдсан хүн амын орлогын болон өрхийн гишүүдийн эдийн засгийн асуудалд оруулсан хувь нэмрийг харуулав. Төсөлд хамрагдснаар хүн амын 38.9 хувийнх нь өрхийн орлого нэмэгдсэн байна. Өрхийн гишүүдээ ажилтай болоход нь төсөлд хамрагдагсдын 38.5 хувь нь нөлөөлж чаджээ.

Төсөлд хамрагдсан хүн амын 20 орчим (эрэгтэйчүүдийн 21.4 хувь, эмэгтэйчүүдийн 18.6 хувь) хувь нь төсөлд хамрагдснаар өрх нь оршин суугаа газар/хашаагаа өмчилж авч чадсан байна.

<i>Хүснэгт 4.1 Төсөлд хамрагдагсдын хувийн жин, өрхийн эдийн засагт оруулсан хувь нэмэр, сургалтын дараа</i>		
Сонгосон үзүүлэлтүүд	Бүгд	Тоо
Өрхийн орлогод өөрчлөлт гарсан байдал		
Нэмэгдсэн	38.9	81
Хэвээрээ	58.7	122
Буурсан	2.4	5
Өрхийн гишүүдээ ажилтай болгоход нөлөөлсөн байдал		
Нөлөөлж чадсан	38.5	80
Нөлөөлж чадаагүй	37.5	78
Оролцох шаардлагагүй	24.0	50
Газар/хашаагаа өмчилж авч чадсан эсэх		
Чадсан	18.8	39
Чадаагүй	81.2	169
Өрхөд ажил хийж буй хүүхэд байгаа эсэх		
Байгаа	6.3	13
Байхгүй	93.7	195
Өрхөд сургууль завсардсан хүүхэд байгаа эсэх		
Байгаа	14.4	30
Байхгүй	85.4	178
Бүгд	100.0	208

Сургалтын дараах судалгаанд хамрагдагсдын 6.3 хувь нь насанд хүрээгүй хүүхэд ажиллуулж буй өрхөд, 14.4 хувь нь сургууль завсардсан хүүхэдтэй өрхөд амьдарч байв. Судалгаанд хамрагдсан сургууль завсардсан хүүхэдтэй өрхийн хүн амын бараг тал нь буюу 49.1 хувь нь хүүхдийг сургуульд нь буцаан явуулахад шахалт үзүүлнэ гэжээ.

Сургалтанд хамрагдсны дараа өрхөд нь нийгмийн халамжийн үйлчилгээ авах шаардлагатай хүн байдаг оролцогчдын 66.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмжээ авч чаддаг, 50.4 хувь нь нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдаж чадаж байгаа гэжээ (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2 Төсөлд хамрагдагсдын хувийн жин, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломж, сургалтын өмнө ба дараа

Сонгосон үзүүлэлтүүд	Сургалтын өмнө		Сургалтын дараа	
	Бүгд	Тоо	Бүгд	Тоо
Өрхийн гишүүд тэтгэвэр/тэтгэмжид хамрагдаж чадаж байгаа эсэх				
Чадаж байна	83.8	78	66.0	70
Чадахгүй байна	16.2	15	33.0	36
Бүгд	100.0	93	100.0	106
Нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэх				
Чадаж байна	32.9	54	50.4	63
Чадахгүй байна	67.1	110	49.6	62
Бүгд	100.0	164	100.0	208

Төсөлд хамрагдагсдын 23.6 хувь нь сургалтын дараа өрхийн гишүүдээ өөрийн харьяа өрхийн эмнэлгээр үйлчлүүлж чаддаг болсон байна. Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд өрхийн гишүүдийн өрхийн эмнэлэгт хамрагдаж чадсан байдал эрэгтэйчүүдийнхээс 3 дахин өндөр байна. Эндээс, өрхийн гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн асуудалд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь тодорхой харагдаж байна.

5. Төслийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Төслийн үйл ажиллагаанд оролцогчдын өгч буй ерөнхий үнэлгээ

Төсөлд хамрагдсандаа болон төслийн үйл ажиллагаанд хүмүүс сэтгэл ханамжтай байна. Төслийн сургалтуудад хамрагдсан эрэгтэйчүүдийн 28.6 хувь, эмэгтэйчүүдийн 43.3 хувь нь хангалттай мэдээлэл, мэдлэг олж авсан гэж үнэлж байна. Харин талаас илүү (эрэгтэйчүүдийн 71.4 хувь, эмэгтэйчүүдийн 55.2 хувь) нь боломжийн мэдээлэл, мэдлэгтэй болсон гэжээ.

Төсөлд хамрагдснаар өөрийн хүсч байсан үр дүндээ хүрсэн гэж эрэгтэйчүүдийн 85.7 хувь, эмэгтэйчүүдийн 87.1 хувь нь үнэлсэн байна.

Төсөлд хамрагдагсдын 14.9 хувьд нь төслийн сургалтанд хамрагдахад нь ямар нэгэн бэрхшээл тохиолдож байжээ. Бэрхшээл тохиолдож байсан гэж хариулсан эмэгтэйчүүдийн (15.5) хувь эрэгтэйчүүдийнхээс 2 дахин өндөр байна. Анх мэргэжлийн чиглэлээ сэтгэлийн хөөрлөөр буруу сонгосон, мэргэжлийн дадлага, эсвэл төгсөх шалгалт өгөхөд зарим мэргэжлийн хувьд жишээ нь, тогооч, үсчин, гоо сайхны шалгалт өгөхөд өөрсдөө материалаа гаргахад мөнгөгүй байх, бүлэг цугларах, дамжаандаа явахад өмсөж буй гутал, хувцаснаасаа ичих, унааны мөнгөгүй байх гэт мэт хүндрэл бэрхшээлүүд гарч байжээ.

*Төгсөх шалгалт өгөхөд өөрсдөө материалаа гаргасан. Миний хувьд хамгийн бага зардал гаргахыг хичээж 5000-7000 төгрөгөөр нэг тиймэрхүү материал авсан. Уг нь сайн материалтай бол илүү сайн хоол хийх л байсан. Материалдаа тааруулаад л хоолоо хийсэн. Өөрсдийнхөө төлөө явж байгаа юм чинь ах дүүгээрээ явж мөнгө зээлсэн. Одоо өртэй л байна.
(Д. 30 настай, эмэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, баталгаагүй гэр бүлтэй)*

Сургалт уруу бөөнөөр нийлж алхдаг. Эндээс 4 зам хүртэл (5 гаруй километр). Хичээлээ тасалж байгаагүй, харин хоцордог.

(Д. 25 настай, эмэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, гэр бүлтэй)

Касс, худалдагчийн дадлага хийж байхад хамгийн хэцүү. Би А. Нэртэй бөөний дэлгүүрт дадлага хийж байсан. Дэлгүүрээ юм дутлаа гээд юм л бол харддаг. Ер нь төсөлд ядуу зүдүү хүмүүс хамрагддаг гэсэн байр суурь, ойлголттой байдаг юм уу харьцаж буй хандлага нь муу байдаг. Хүнд дандаа хардуулаад байхад очмооргүй санагддаг. Ганц би ч биш, ер нь манай касс, нярвын сургалтын хүүхнүүдэд ийм зүйл тохиолддог.

(М. 29 настай, эмэгтэй, бүрэн бус дунд боловсролтой, баталгаагүй гэр бүлтэй)

Цаашид анхаарах асуудлуудын талаарх төсөлд оролцогчдын санал

Төсөлд хамрагдсан бүх хүмүүс “Шилжин суурьшигч тантай хамт” төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь хүн амын амьжиргаанд ихээхэн тустай байна гэжээ.

Шилжин суурьшигч тантай хамт төслийн цаашдын үйл ажиллагааг сайжруулахын тулд сургалтын ямар үйл ажиллагаанд илүү анхаарал шаардлагатай гэж бодож байна вэ гэсэн асуултанд 70 гаруй хувь нь тодорхой санал байхгүй, боломжийн сайн байсан гэж хариулжээ. Гэхдээ үлдсэн 30 орчим хувь нь сургалтанд хамрагдагсдын гүнд нь орж ажиллах, нас, хүйс ялгаварлахгүй байх, дадлагын цагийг нэмэгдүүлэх, оролцогчдын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, хичээлд мэргэжлийн ойлгомжгүй үг хэллэгээс зайлсхийх хэрэгтэй байна гэсэн саналуудыг өгчээ.

Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн 68.6 хувь, эрэгтэйчүүдийн 42.9 хувь нь төслийн үйл ажиллагааны чухам юун дээр нь илүү анхаарах хэрэгтэй байна вэ гэсэн асуултанд тодорхой санал өгөхгүй, үйл ажиллагаа, зохион байгуулалт сайн байсан гэж үнэлсэн байна. Үлдсэн хувь нь ном, сурах бичиг, гарын авлага, материалаар хангах, зохион байгуулалтыг илүү нарийн болгох, онол болон дадлагын хичээлүүдийн цагийг тэнцвэржүүлэх хэрэгтэй байгааг илүү зөвлөж, санал болгожээ.

Дүгнэлт

Төсөл зорилтот бүлгийнхээ хүн амыг төлөөлөн авч чадсан байна. Тухайлбал, төсөлд хамрагдагсдын дийлэнх нь олон ам бүлтэй, шилжин ирсэн, өрхийн гишүүдийн ажил эрхлэлт нь доогуур ядуу өрхөөс сонгогдсон байна. Хувь хүний шинж байдлын хувьд, төсөлд хамрагдагсад нь залуу насны, сүүлийн таван жилд хотод шилжин ирсэн бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой байв.

Төсөлд хамрагдагсдын гуравны нэг нь шилжин ирэлтээ бүртгүүлээгүй байсан ба гол шалтгаан нь орон нутгаасаа шилжүүлэг хийлгээгүй, бичиг баримтын зөрчилтэй, санхүүгийн боломж муу байгаагаас болжээ. Харин төсөлд хамрагдснаар тэдний гуравны нэг нь бүртгүүлсэн байна. Бүртгэлд хамрагдаж чадснаар өөрийн хорооны харьяа өрхийн эмнэлгээр өрхийн гишүүд нь үйлчлүүлдэг болсон хүмүүсийн хувийн жин өсчээ. Төсөлд хамрагдснаар өрхийн орлогод өөрчлөлт гарчээ. Гэхдээ төсөлд хамрагдсны дараа хүмүүсийн ердөө тал хувь нь ажил идэвхтэй хайсан байна.

Төсөлд хамрагдсан хүн амын хууль эрх зүйн мэдлэг, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг эрс дээшилсэн байна. Төсөлд оролцсноор эрүүл мэндийн даатгалд хамрагдах, энэ чиглэлээр өөрийн ойр дотны хүмүүстээ зөвлөх, даатгалаа хөөцөлдөж хийлгэх мэдлэг нь ч дээшилжээ. Сургууль завсардсан хүүхдүүдээ сургуульдаа эргэн сурахад нь нөлөөлөх, ажилгүй насанд хүрэгчдийг ажилтай болгоход нь ч төсөлд оролцогчид нөлөөлж чаджээ. Сургалтад хамрагдснаар найз нөхөдтэй болж, бие биедээ туслах, ажил хөдөлмөр хийх боломж нь нэмэгдэн, өөртөө итгэх итгэлтэй болсон байна. *Эцэст нь*, төсөлд хамрагдагсдын дийлэнх нь өөрийн хүсч байсан үр дүндээ хүсч чадсан бөгөөд сэтгэл хангалуун байна.

Төслийн үр дүнг нэгдсэн байдлаар доорх үзүүлэлтүүдээр ерөнхийд нь дүгнэж болох юм.

Д/д	Үзүүлэлтүүд	Хувь
1. Хууль эрх зүйн мэдлэгийн өөрчлөлт		
1.1	Хууль эрх зүйн мэдлэгийн өсөлтийн хувь	
	- Газрын тухай хууль эрх зүйн мэдлэгийн өсөлт	92.3
	- Хөдөлмөрийн хуулийн талаарх мэдлэгийн өсөлт	29.3
	- Ядуурлын түвшинг тодорхойлох мэдлэгийн өсөлт	30.3
	- Хүчирхийллийн талаарх хууль эрх зүйн мэдлэгийн өсөлт	83.6
2. Нийгмийн асуудлуудад гарсан өөрчлөлт		
2.1	Эрүүл мэндийн даатгалгүй хүн амд төслийн явцад эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувийн жин	
	- Нийт хүн ам	22.7
	- Эмэгтэй хүн ам	24.1
	- Эрэгтэй хүн ам	0.0
2.2	Бүртгэлгүй хүн амд төслийн явцад бүртгэлтэй болсон хүн амын эзлэх хувийн жин	
	- Нийт хүн ам	34.2
	- Эмэгтэй хүн ам	31.8
	- Эрэгтэй хүн ам	57.2
3. Өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт		
3.1	Төсөлд хамрагдсан хүн амд төсөлд хамрагдснаар өрхийн орлогоо нэмэгдүүлж чадсан хүн амын эзлэх хувийн жин	38.9
3.3	Газар/хашаагаа өмчилж авч чадсан хүн амын эзлэх хувийн жин	
	- Нийт хүн ам	18.8
	- Эмэгтэй хүн ам	18.6
	- Эрэгтэй хүн ам	21.4
4. Мэдээлэл авах боломж, нийгмийн сүлжээнд гарсан өөрчлөлт		
4.1	Төсөлд хамрагдснаар хангалттай мэдээлэл, мэдлэгтэй болсон хүн амын хувийн жин	
	- Нийт хүн ам	42.3
	- Эмэгтэй хүн ам	43.3
	- Эрэгтэй хүн ам	28.6
4.2	Төсөлд хамрагдахаас өмнө болон төсөлд хамрагдсны дараа сургууль завсардсан хүүхэдтэй өрхийн хувийн жингийн бууралт	19.3
4.3	Төсөлд хамрагдсан хүн амд төсөлд хамрагдснаар өрхийн гишүүдээ ажилтай болоход нь нөлөөлж чадсан хүн амын эзлэх хувийн жин	38.5
5. Сэтгэл ханамж		
5.1	Төсөлд хамрагдснаар хүсч байсан үр дүндээ хүрсэн хүн амын эзлэх хувийн жин	
	- Нийт хүн ам	87.0
	- Эмэгтэй хүн ам	87.1
	- Эрэгтэй хүн ам	85.7

Бодлогын зөвлөмж

Судалгааны үр дүн дээр тулгуурлан дараах бодлогын зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- Олон нийтийн оролцоог идэвхжүүлсэн энэхүү төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжүүлэн, бусад *дүүрэг хороодод зориулсан загвар төсөл болгон ашиглах;*
- *Мэргэжлийн сургалтын чиглэлүүдийг өргөтгөж, ажлын байранд дадлага хийх боломжийг нь нэмэгдүүлэх;* Үүний тулд төслийн дотоод сургалт зохион байгуулж буй байранд, иргэдийн оршин суугаа газартай ойролцоо жижиг үйлчилгээний цэгүүдийг байгуулж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх замаар дадлагажих, цаашдаа төсөлд хамрагдагсад бүлгээрээ хамтран бизнесийн үйл ажиллагаагаа явуулах үндсийг нь тавьж өгөх;
- Хууль эрх зүй, эрүүл мэндийн мэдлэг, өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга зүйн асуудлаар мэдээ, мэдээллийг хангалттай хэвлэн нийтлүүлж, олон нийтэд тараах, ухуулан сурталчлах ажилд хорооны түвшинд нэгэнт бий болсон *иргэдийн сүлжээг ашиглах;*